



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/433

Улаанбаатар хот

Зоонозын халдварт өвчний бэлэн
байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.7, Шадар сайдын 2023 оны А/28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160, А/161 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зоонозын халдварт өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (хурандаа Ц.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн
114/23 дугаар тушаалын хавсралт



ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУ АРГА ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас мал, амьтнаас шууд ба шууд бус хавьтлаар хүний бие махбодод орж үүсгэдэг 300 гаруй өвчин байдгаас 160 орчим нь мал, амьтнаас хүнд халдварладаг зоонозын халдварт өвчин байдаг.

2024 он гарсаар улсын хэмжээнд зоонозын шалтгаант 930 дуудлага бүртгэгдсэнээс 50 орчим хувийг Хачигт энцефалит, Бэтэг, Тарваган тахал, Боом өвчний сэжигтэй тохиолдол эзэлж байна.

Тус төлөвлөгөө нь Зоонозын халдварт өвчний эсрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлэх Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах удирдлагын баримт бичиг болно.


Хоёр. Зорилго

Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг орон нутгийн хэмжээнд салбар хоорондын оролцоог ханган шуурхай хэрэгжүүлэн, эрсдэлийг бууруулах, хохирол багатай даван туулахад оршино.

Гурав. Хамрах хүрээ

Энэхүү төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд хэрэгжүүлнэ.

Дөрв. ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮДҮҮВЧ



ТОВЧИЛСОН НЭР, ТЭМДЭГТИЙН ТАЙЛБАР

Д/Д	Таних тэмдэг	Товчилсон нэр	Тайлбар
1.		YAБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
2.		ТЦБХСБ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага
3.		УОК ШШ, ОБЕГ	Улсын онцгой комиссын Шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газар
4.		YAБ	Үндэсний аврах бригад
5.		ОБГ	Онцгой байдлын газар
6.		ГХАМА	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги
7.		Х.ЦЭГ	Хяналтын цэг
8.		БДРХ	Богино долгионы радио холбоо
9.		ХБДРХ	Хэт богино долгионы радио холбоо
10.		ДДС	Дахин дамжуулах станц
11.		ЦДХ	Цахим дүрс холболт
12.			Jetsi, rocket chat
13.		АТС	АТС болон үүрэн холбоо
14.		НТ	Нууцлагдсан телефон
15.		СХ	Сансрын холбоо
16.		ХК	Хяналтын камер

Тав. ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ БЭЛЭН БАЙДАЛ,
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Удирдан зохицуулах чиглэл хариуцсан байгууллага	Хугацаа	Дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5
Нэг. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлэн байдлын талаар				
1	Хүн амд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны материал бэлтгэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэх мэдээлэл хүргэх	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба, мэргэжлийн анги, Хэвлэл олон нийттэй харилцах алба	Тухай бүрт	ТОНОББ
2	Салбар хоорондын хамтарсан дадлага сургуулилт хийх /Иж бүрэн, команд штабын дадлага сургууль, бусад/	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	ОБЕГ
3	Товлолт вакцинжуулалтад алба хаагчдыг хамруулах	ТОНОББ, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	ОБЕГ
4	Дайчлагдан ажиллах хүний нөөцийн судалгаа гаргаж, бэлэн байдлыг хангах	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	ТОНОББ
5	Алба, мэргэжлийн ангиудын томилгоот хүч хэрэгслийн тооцоо, нөөцийн судалгаа, бэлэн байдлыг хангуулах	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги	Тухай бүрт	ТОНОББ
Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын талаар				
6	Шуурхай штаб байгуулах	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
7	Шуурхай штабын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажлын зураг бэлтгэх	ТОНОББ, Цэргийн штаб	Тухай бүрт	ОБЕГ
8	Халдварын голомтод шуурхай бүлэг томилон ажиллуулах	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
9	Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох	ТОНОББ, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги	Тухай бүрт	ОБЕГ
10	Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалтын мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн тооцоо, нөөцийн судалгаа гаргах	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги	Тухай бүрт	ТОНОББ
11	Мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн хорио цээр болон хязгаарлалтын дэглэм тогтоох, цуцлах тухай шийдвэр гаргах	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ

1	2	3	4	5
12	Халдварын голомтод ажиллах хүч хэрэгслийг хуваарилах, шаардлагатай хүч хэрэгслийг дайчлах, байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах	Аймгийн Онцгой комисс, Сумын Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
13	Халдварт өвчний хяналт сэргийлэлтийн чиглэлээр гаргасан тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах /Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160, А/161 дүгээр тушаал/	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	АОК
14	Эрсдэлийн үнэлгээ хийх, мэдээлэл солилцох /Шадар сайдын 2023 оны А/28 дугаар тушаалын дагуу шуурхай зохион байгуулах/	Аймгийн Онцгой комисс, Сумын Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
15	Хяналтын цэг байгуулж, тохижуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих	Аймгийн онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
16	Хяналтын цэгт баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар боловсруулж мөрдүүлэх	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	АОК
17	Хүмүүнлэгийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
18	Голомтын бүсэд байгаа иргэдэд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийх, халдвараас сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж өгөх	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	ТОНОББ
Гурав. Хорио цээр болон хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлэх арга хэмжээний талаар				
19	Олон нийтийг хамарсан арга хэмжээ (хурал, цуглаан, сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа, спорт, урлагийн тоглолт, хурдан морины уралдаан, бөхийн барилдаан гэх мэт) зохион байгуулахыг хориглох, хугацааг өөрчлөх	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
20	Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
21	Агаарын болон нийтийн тээвэр, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг хориглох, чиглэлийг зохицуулах	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
22	Өвчин гарсан болон тархаж болзошгүй газар нутагт тархвар судалгааг хийх, 1 дүгээр хавьтлыг бүрэн тогтоох, эмчийн хяналтад авах	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	Гамшгаас хамгаалах Хэв журам сахиулах алба
23	Хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдыг байрлах байр, хоол хүнс, шатах тослох материал болон бусад бараа материалаар хангах	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
24	Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд дэглэм зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан тушаалтанд хариуцлага тооцох	Гамшгаас хамгаалах Хэв журам сахиулах алба	Тухай бүрт	ТОНОББ

1	2	3	4	5
25	Голомтын бүсэд зайлшгүй шаардлагаар орох, гарах зөвшөөрлийг олгох	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
26	Голомтын бүс болон хяналтын цэгт ажиллаж буй алба хаагч, иргэдийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	ТОНОББ
27	Байнгын болон эцсийн халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба, Мал эмнэлгийн газар	Тухай бүрт	Аймгийн Онцгой комисс
28	Хүн амд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны материал бэлтгэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэх	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба, Хэвлэл олон нийттэй харилцах алба	Тухай бүрт	Аймгийн Онцгой комисс
29	Авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба, олон нийттэй харилцах алба	Тухай бүрт	Аймгийн Онцгой комисс
30	Гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Гамшгаас хамгаалах Хэв журам сахиулах алба	Тухай бүрт	Аймгийн Онцгой комисс
31	Зоонозын өвчний улмаас нас барсан хүн, үхсэн мал, амьтны сэг зэмийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	-
Дөрөв. Бусад арга хэмжээний талаар				
32	Үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар удирдах дээд байгууллагад тухай бүр мэдээлэх	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	ТОНОББ
33	Голомтын бүс дэх иргэдэд хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатах тослох материал болон бусад бараа материалаар хангах ажлыг зохион байгуулах	Гамшгаас хамгаалах Хүнс, хөдөө аж ахуйн алба	Тухай бүрт	Аймгийн Онцгой комисс
34	Бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх, зохиомол хомсдол бий болгохоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	-
35	Зоонозын халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаанд зарцуулсан зардлын тайлан гаргах	Аймгийн Онцгой комисс	Тухай бүрт	Аймгийн Онцгой комисс
36	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг дээд шатны байгууллагад хүргүүлэх	Аймгийн Онцгой комисс, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба	Тухай бүрт	Аймгийн Онцгой комисс